

Ерөнхийлөгч  
Хэнри Б. Айринг

Тэргүүн Зөвлөлийн  
нэгдүгээр зөвлөх



# Үйлчлэл ба мөнх амьдрал

**А**врагч бол хувиа хичээдэггүй үйлчлэлийг бидэнд харуулсан үлгэр жишээ юм. Түүний төгс амьдрал Тэнгэрлэг Эцэг болон Эцэгийнхээ бүх хүүхдэд үйлчлэхэд зориулагдсан билээ. Эцэг болон Хүүгийн нэгдсэн зорилго нь бид бүгдэд үхэшгүй байдлын бэлэг болон мөнх амьдралын адислалыг өгөх явдал юм (Мосе 1:39-ийг үзнэ үү).

Мөнх амьдралын шаардлагыг хангахын тулд бид Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан өөрчлөгдөж, нүглээсээ цэвэршин мөн дахин төрөх ёстой. Харин наймаас доош насны бяцхан хүүхдүүд нүгэлгүй бөгөөд Цагаатгалаар дамжуулан гэтэлгэгддэг (Мозая 3:16, 21; Моронай 8:10–12-ыг үзнэ үү).

Хариуцлагын насанд хүрсэн бид бүгдийн хувьд нүглээсээ цэвэрших болон мөнх амьдралд бэлтгэх боломж олгодог гайхамшигтай төлөвлөгөө бий. Тэрхүү бэлтгэл нь санваарын эрх мэдлээр баптисм хүртсэнээр мөн Ариун Сүнсний хүлээн авалтаар эхэлдэг. Тэгээд бид Аврагчийг үргэлж дурсан санаж мөн түүний бидэнд өгсөн зарлигуудыг сахих ёстой.

Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан нүглийн өршөөлийн мэдрэмжээс ирэх баяр баясгалангийн талаар Хаан Бенжамин Мормоны Номон дахь өөрийн хүмүүст хэлсэн байдаг. Мөн тэрээр тэдэнд хандан, нүглийн ангижралаа хадгалж үлдэхийн тулд

тэд хүүхдүүддээ нэг нэгэндээ үйлчлэх болон тэдний эргэн тойронд байгаа хүмүүсийн материаллаг болон сүнслэг хэрэгцээнд аль болох өгөөмрөөр хандах хэрэгтэйг заах ёстой хэмээн тунхагласан юм. (Мозая 4:11–16-г үзнэ үү.)

Тэрээр бас “Мөн болгоогтун, би та нарт эдгээр зүйлийг та нар мэргэн ухааныг сурч болохын тулд хэллээ; та нар бусдадаа үйлчилж байгаа нь та нар зөвхөн Бурхандаа үйлчилж байгаа гэдгээ мэдэж болохын тулд буюу” (Мозая 2:17) хэмээн заажээ.

Есүс Өөрийн сайн мэдээг зааж мөн сайныг үйлдэхээр явсан. (Үйлс 10:38 -ыг үзнэ үү). Тэр өвчтэй хүмүүсийг эдгээсэн. Тэрээр үхэгсдийг босгосон юм. Хоол хүнсгүй, өлсгөлөн байсан мянга мянган хүнийг Тэрээр Өөрийн хүчээр хооллосон (Матай 14:14–21; Иохан 6:2–13-ыг үзнэ үү). Амилсныхаа дараа Тэрээр Өөрийн хэдэн төлөөлөгчийг Галилын тэнгисийн эрэгт ирэх үед хооллосон юм (Иохан 21:12–13-ыг үзнэ үү). Америк тивд Тэрээр өвчнийг эдгээж мөн бяцхан хүүхдүүдийг нэг бүрчлэн адисалсан билээ (3 Нифай 17:7–9, 21-ийг үзнэ үү).

Төлөөлөгч Иаков Их Эзэний бидний төлөө хийсэн бүхэнд талархсан талархлаас хэрхэн бусдад үйлчлэх хүсэл төрдөг тухай заасан.

“Харин мартамхай сонсогч бус, хэрэгжүүлэгч

болж, эрх чөлөөний хууль болох төгс хуулийг ня-  
хуур үздэг бөгөөд түүгээр байдаг хүн нь үйлс дотроо  
ерөөгдөх болно. . . .

“Бидний Бурхан ба Эцэгийн өмнө цэвэр ариун  
бөгөөд бузартаагүй сүсэглэл бол зовж зүдрэх цагт нь  
өнчин хүмүүс, бэлэвсэн эхнэрүүдийг эргэж тойрон,  
өөрийгөө хамгаалан дэлхийгээс бохирдохгүй байх  
нь ажгуу” (Иаков 1:25, 27).

Таны ариуссан гэдгийн нэг баталгаа нь Аврагчийн  
төлөө бусдад үйлчлэх өсөн нэмэгдэж буй хүсэл юм.  
Гэрийн болон айлчлагч багшлаат нь хүнд хэцүү бус  
харин илүү баяр баясгалантай ажил болж байна. Та  
сургууль болон нийгэм дэх ядуу хүмүүсийг халамжлах  
сайн дурын ажилд илүү ихээр оролцож байгаагаа мэд-  
дэх болно. Тэр байтугай та гачигдалтай байгаа тэдэнд  
өгөх мөнгөөр тарчигхан байгаа үедээ ч гэсэн хүмүүст  
илүү өгч болохын тулд өөрт тань арай илүү байсан  
ч болоосой хэмээн хүсэх болно (Мозая 4:24-ийг үзнэ  
үү). Та хүүхдүүдээ үйлчилж мөн бусдад хэрхэн үйлч-  
лэхийг тэдэнд заах хүсэлтэй болох болно.

Таны мөн чанар өөрчлөгдсөнөөр магтаал сайшаал  
хүлээлгүй илүү их үйлчлэл үзүүлэх хүсэлтэй байгаа-  
гаа та мэдрэх болно. Зоримог, шийдэмгий байдлаар  
мөнгө болон үйлчлэлийн агуу бэлгийг өгсөн Авраг-  
чийн шавь нарыг би мэддэг бөгөөд өөр хэн нэгэн  
бус харин Бурхан болон Түүний хүүхдүүд л энэ  
талаар мэддэг. Бурхан тэдний үйлчлэлийг хүлээн зөв-  
шөөрч, энэ амьдралд нь адисалснаар мөн ирэх мөнх  
амьдралд ч тэднийг адислах болно (Матай 6:1–4 ;  
3 Нифай 13:1–4-ийг үзнэ үү).

Та бусдад үйлчлэх зарлигийг дагаснаар (Матай  
22:39-ийг үзнэ үү), бардамнал тань өөрчлөгдөж  
байгааг мэдэрсэн билээ. Аврагчийн Төлөөлөгчдийг  
хэн нь тэдний дунд хамгийн агуу нь болох талаар  
маргалдах үед Тэрээр үүнийг залруулжээ. Тэрээр  
хэлэхдээ:

“Та нар удирдагчид гэж битгий дуудуул: Та нарын  
Удирдагч Ганц бөгөөд Тэр нь Христ юм.”

“Харин та нарын дундах хамгийн агуу нь зарц  
болог” (Матай 23:10–11) гэжээ.

Аврагч бидэнд бусдад хэрхэн үйлчилж сурахыг  
заадаг. Тэрээр төгс үйлчилсэн мөн бид Түүний адил  
хэрхэн үйлчлэхийг шат шатаар (С ба Г 93:12–13-  
ыг үзнэ үү) сурах ёстой. Бид хийсэн үйлчлэлээрээ

дамжуулан Түүнтэй илүү адил болж чадна. Тэрээр  
дайснуудаа хайрласны адилаар бид ч мөн тэднийг  
хайрлахын төлөө зүрх сэтгэлийнхээ бүхий л эрч  
хүчээр залбирах болно (Матай 5:43–44; Моронай  
7:48-ыг үзнэ үү). Эцэст нь бид Түүнтэй болон Тэнгэр-  
лэг Эцэгтэйгээ хамт амьдрахын тулд мөнх амьдралыг  
хүлээн авахуйц зохистой болох болно.

Бид Аврагчийн сургаал болон үлгэр жишээг да-  
гаснаар илүү төгс үйлчилж чадна гэдгийг би амлаж  
байна.

---

## ЭНЭХҮҮ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Арванхоёрын чуулгын ахлагч М. Рассэлл Баллард  
биднийг үйлчлэх боломжийн төлөө залбирахад урам-  
шуулан дэмжихдээ: “Өглөө бүр залбирахдаа Тэнгэрлэг  
Эцэгээс Түүний хайртай хүүхдүүдийн нэгэнд үйлчлэх  
боломжийг таньж мэдэхэд удирдахыг гуй. Тэгээд  
өдрийн турш . . . тусламж хэрэгтэй хэн нэгнийг оло-  
хоор яв” (“Санаа сэтгэлээ бүрэн зориулсан байх нь,”  
*Ensign* эсвэл *Лиакхона*, 2012 оны 11 дүгээр сар 31) гэсэн  
юм. Үйлчлэх боломжийн төлөө өглөө бүр залбирах  
зорилго тавьж мөн өдрийн туршид үүнийг биелүүлэ-  
хийг эрэлхийлэхэд заадаг хүмүүсээ урина уу.

## ӨСВӨР ҮЕИЙНХЭНД

### Түүний залбирлын хариу

Сифилиле Кумало

Нэгэн орой өөр итгэл бишрэлтэй найз маань  
манайд зочилсон юм. Би судраа ихэвчлэн ганцаа-  
раа судалдаг бөгөөд тэр орой судруудаа судлахаар  
гаргаж тавьсан байлаа. Би тэр найзыгаа хамт судраас  
судлахад урихаар өдөөгдсөн боловч зориг хүрэлгүй  
ганцаараа судалж эхлэв. Сүнсний өдөөлтийг үгүйсгэ-  
сэн гэдгээ би мэдэж байлаа. Хэдэн минутын дараа “Чи  
надтай хамт судар судлахыг хүсэж байна уу?” хэмээн  
би болгоомжтой асуулаа. Найз маань ямар ч эргэл-  
зээгүйгээр “тэгье” гэж хариулав.

Тэгээд бид Мормоны Номоос уншив. Тэр надаас  
хэдэн асуулт асуусан бөгөөд би асуултад нь хариулах  
үедээ Сүнс намайг удирдаж байгааг мэдэрч бай-  
сан юм. Би Мормоны Ном үнэн талаар гэрчлэлээ

хуваалцав. Үүний дараа тэр надад “Би бүтэн өдрийн турш айдастай байж, их уйлсан байсан. Чамайг надаас судар хамт уншихыг хүсэх үед би Бурханд хандан тусламж хүсэн залбираад дөнгөж дууссан байсан юм. Надад одоо илүү аятайхан байгаага мэдэрч байна. Баярлалаа” гэж билээ.

Их Эзэн намайг Түүний хүүхдүүдийн нэгэнд хэрэгцээнийх нь дагуу үйлчлэх мөн залбиралд нь хариулах зэмсэг болгон ашигласан юм. Сүнсний өдөөлт нь мэргэн, алдар суут Эцэгээс ирсэн тэнгэрлэг заавар гэдгийг би мэднэ. Биднийг айдсаа ардаа орхих үед бид дуулгавартай байдлаараа дамжуулан Өөрийн хүчийг харуулах боломжийг Түүнд олгодог.

*Энэхүү өгүүллийн зохиогч Өмнөд Африкийн Гаутенд амьдардаг.*

## ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

### Үйлчлэх арга замуудыг эрж хай

**Т**а Есүс Христийг дагаж мөн бусдад үйлчлэхийг сонгож болно. Гэр бүлийнхээ гишүүнд юм уу найздаа үйлчилж байгаагаар өөрийгөө зураад өдөр бүр найрсаг байхыг өөрт чинь сануулах газарт үүнийгээ тавиарай.

© 2014 Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан. АНУ-д хэвлэв. Англи эхийн зөвшөөрөл: 6/13 Орчуулгын зөвшөөрөл: 6/13. *First Presidency Message, March 2014*. Mongolian. 10863 363-ын орчуулга



# Есүс Христийн тэнгэрлэг зорилго: Дэлхийн гэрэл

*Энэ материалыг залбиран судалж мөн юу хуваалцахаа мэдэхийг эрэлхийлнэ үү. Аврагчийн амьдрал ба зорилгыг ойлгох нь таны Түүнд итгэх итгэлийг хэрхэн нэмэгдүүлж мөн айлчлагч багшаар дамжуулан халамж тавьдаг хүмүүсийг тань хэрхэн адислах вэ? Дэлгэрэнгүй мэдээллийг [reliefsociety.lds.org](http://reliefsociety.lds.org)-аас үзнэ үү.*

Итгэл, Гэр бүл, Халамж

*Энэ бол Аврагчийн зорилгын онцлог талуудын талаарх Айлчлагч багшийн цуврал захиасуудын нэг хэсэг юм.*

**Б**ид Есүс Христийг дэлхийн гэрэл гэдгийг ойлгосноор Түүнд итгэх итгэлээ нэмэгдүүлж мөн бусдад гэрэл нь болдог. Христ Өөрийн үүргийг “дэлхийд ирдэг эрэгтэй [эмэгтэй] хүн бүрийг гэрэлтүүлдэг үнэн гэрэл” хэмээн гэрчилсэн байдаг (С ба Г 93:2) бөгөөд “дэлхийд туяарч болохын тулд гэрлээ өргөхийг” биднээс хүссэн юм (3 Нифай 18:24).

Манай бошиглогчид мөн Христийн гэрлийн талаар гэрчилсэн билээ. Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх, ерөнхийлөгч Хэнри Б. Айринг хэлэхдээ: “Аврагчтай илүү адилхан амьдрахаар хичээхийг сонгох бүрд гэрчлэл чинь улам бэхжих болно. Тэр бол Дэлхийн Гэрэл гэдгийг та нар өөрсдөө мэдрэх цаг ирнэ. . . . Амьдралдаа буй Христийн гэрлийг та бусдад тусгаж чадна” хэмээжээ.<sup>1</sup>

Арванхоёрын чуулгын ахлагч Квинтин Л. Күк бид хэрхэн дэлхийн гэрэл болох талаар хэлэхдээ: “Бид гэр бүлээ хамгаалж мөн бидний нийгэм дэх гэрэл, найдвар

болон ёс суртахууныг хадгалж үлдэхийн тулд сайныг үйддэгч хүмүүстэй хамтран, чадах бүхнээ хийх ёстой” гэжээ.<sup>2</sup>

## Судруудаас

Иохан 8:12; Сургаал ба Гэрээ 50:24; 115:5

## Бидний түүхээс

Өнөөдөр хожмын үеийн гэгээнтэн эмэгтэйчүүд гэрлээ үргэлжлүүлэн өргөх болно.

Гэр бүлээсээ ганцаараа хожмын үеийн гэгээнтэн бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй, ганц бие нэгэн эгч Хятадын Хонгконг дахь тэнгэр баганадсан барилгын 80 давхарт өөрөө болон түүний зочид сүнсний нөлөөг мэдэрч чадах гэрийг бий болгожээ. Тэр эмэгтэй судрууд, Халамжийн Нийгэмлэгийн гарын авлагууд болон сүмийн дууллын номоо өөртөө их ойрхон хадгалдаг байсан аж. Тэрээр өвөг дээдсийнхээ төлөө ёслолуудыг гүйцэтгэхийн тулд ариун сүм рүү аялсан байна.<sup>3</sup>

Бразил дахь нэгэн зөв шударга эх хүүхдүүдээ сайн мэдээний гэрэлд өсгөжээ. Түүний улаан тоосгон байшинг Хүүхдийн хэсгийн

дуунууд дүүргэж, *Лиахона* сэтгүүлээс авсан ариун сүм, Бурханы бошиглогчид болон Аврагчийн зургууд ханыг нь бүрхжээ. Тэр эмэгтэй хүүхдүүдээ гэрээнд төрүүлэхийн тулд нөхөртэйгөө ариун сүмд лацдан холбогдохоор золиослол хийсэн байна. Хүүхдүүдээ гэрэл, үнэн болон сайн мэдээний хүчинд өсгөн хүмүүжүүлэхэд өөрт нь Их Эзэнийг туслаасай хэмээн тэрээр байнга залбирдаг байлаа.<sup>4</sup>

## Эшлэл

1. Хэнри Б. Айринг “Амьд гэрчлэл,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2011 оны 5 дугаар сар, 140.
2. Квинтин Л. Күк, “Гэрэлтэй!” *Ensign* эсвэл *Лиахона*, 2010 оны 11 дүгээр сар, 30.
3. *Миний хаант улс дахь охид: Халамжийн Нийгэмлэгийн түүх ба ажил (Daughters in My Kingdom: The History and Work of Relief Society)* (2011), 163–64-ийг үзнэ үү.
4. *Миний хаант улс дахь охид*

## Би юу хийж чадах вэ?

1. Өнөөдөр дэлхийд гэрэл байх гэдэг нь юу гэсэн утгатай болох талаар ярилцана уу.
2. Христийн гэрлийг дагах нь сорилт бэрхшээлийг тэсвэрлэхэд тань хэрхэн туслах талаар тунгаан бодно уу.